



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/144

Мандалговь

Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн
гэрээг дүгнэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/104 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээ”-г дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн
тусламж үйлчилгээний хэлтсийн дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү,
төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Эрүүл мэндийн газрын анхан шатлалын
тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
Эрүүл мэндийн газрын халдварт өвчний
асуудал хариуцсан мэргэжилтэн
Эрүүл мэндийн газрын эрүүл мэндийн
тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй
байдал хариуцсан мэргэжилтэн
Эрүүл мэндийн газрын эх барих,
эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын өсвөр үе, хүүхдийн
асуудал хариуцсан мэргэжилтэн

“Говийн хөгжил наран” ТТБ-ын тэргүүн

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/108 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100349